



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
АЛБАН ДААЛГАВАР

2024 оны 08 сарын 07 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Улаанбурхан өвчний тархалтаас сэргийлэх,
зарим арга хэмжээний тухай

Улаанбурхан нь вирусийн гаралтай, халдварлалт өндөр өвчний нэг бөгөөд нас баралтын индекс 4-10 хувьтай, өвчлөгсдийн 30 хувьд нь нэг болон түүнээс дээш хүндрэл илэрдэг агаар дуслын замаар халдварладаг халдварт өвчин юм.

Улаанбурхан өвчний тохиолдол Монгол Улсад бүртгэгдсэнтэй холбогдуулан өвчний тандалт, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангах зорилгоор төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт ДААЛГАХ нь:

НЭГ. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА НАРТ:

1.1 Монгол Улсын Шадар сайдын 2023 оны А/28 дугаар тушаалын дагуу Тохиолдлын удирдлагын тогтолцоог идэвхжүүлж, харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж хяналт тавих;

1.2 Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасаг, нэгжийн ор, хүний нөөц, багаж тоног төхөөрөмж, зайлшгүй шаардлагатай эм, тариа, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүн, хүчилтөрөгчийн нөөц, унаа, цахилгааны эх үүсвэр, шатахууны бэлэн байдлыг хангах, нөхөн хангалтыг шуурхай хийх;

1.3 Өмчийн хэлбэр харгалзахгүй бүх шатны эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой улаанбурханы халдварын дэгдэлт бүртгэгдэхээс сэргийлж хүлээн авах, яаралтай тусламж, хэвтүүлэн эмчлэх хэсгүүдэд эрэмбэлэн ангилалт, эрт илрүүлэлтийг сайжруулах арга хэмжээг зохион байгуулан ажиллах цагийн зохицуулалт хийх;

1.4 Аймаг, дүүрэг, сумын түвшинд товлолын болон нэмэлт дархлаажуулалтад хамрагдаагүй 18 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах;

1.5 Харьяа эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн ажилтнуудын улаанбурхан өвчний эсрэг вакцинаар дархлаажсан байдалд судалгаа хийн дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулах;

143240015

1.6 Халууралт, тууралттай хам шинжийн тандалт, улаанбурхан өвчний эмнэлзүй, илрэх шинж тэмдэг, ялган оношилгоо авах арга хэмжээний талаар эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах;

1.7 Халдвараас сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бусад мэдээлэл сурталчилгааны аргыг ашиглан тогтмол түгээж, аж ахуй нэгж, албан байгууллагуудад сэрэмжлүүлэг, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллах;

1.8 Зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллаж байгаа эмч, сувилагч, эмнэлгийн бусад ажилтны илүү цагийн хөлсийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бодож олгож байгаад хяналт тавьж, чиглэл өгч ажиллах.

ХОЁР. ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН ТӨВ, БҮХ ШАТНЫ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРГА, ЗАХИРАЛ НАРТ

2.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний талаар:

2.1.1. Эрүүл мэндийн ажилтны улаанбурхан өвчнөөр өвдсөн, дархлаажуулалтад хамрагдсан байдлын судалгааг хүн тус бүрээр гаргах, улаанбурхан өвчнөөр өвдөөгүй, вакцинд хамрагдаагүй, вакцин хийлгээд 5-аас дээш жил болсон, вакцин хийлгэсэн эсэх нь тодорхойгүй ажилтныг улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг нэн яаралтай зохион байгуулж, хүний нөөцийн бэлэн байдлыг хангах;

2.1.2. Хүнд өвчтөн, жирэмсэн эмэгтэйчүүд, төрсөн эх, хүүхэд, ахмад настанд эмнэлгийн тусламжийг шуурхай үзүүлж, эмч нарын хамтарсан үзлэг, зөвлөгөөнийг хугацаа алдалгүй хийж, эмнэлэг хооронд шилжүүлэх тохиолдолд шилжүүлэх эмнэлэгт урьдчилан мэдэгдэх, эмнэлзүйн багаас зөвлөгөө авч хамтарч ажиллах;

2.1.3. Тохиолдлын тоо ихэссэн үед үндсэн тусламж, үйлчилгээг алдагдуулахгүйгээр хэвтүүлэн эмчлэх орны төлөвлөлтийг хийж, нөөцийн бэлэн байдлыг хангах;

2.1.4. Эмнэлэгт ирсэн халдварын сэжигтэй, халууралт, тууралттай тохиолдлыг тусгаарлан яаралтай мэдээлэх, хамар-залгиур, ам-залгиур, цусны сорьц авч, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн вирус судлалын лабораторид хүргүүлэх;

2.1.5. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүд халдварын шинж тэмдэг илэрсэн үйлчлүүлэгчийг олон хүнтэй хавьтал болохоос сэргийлж дуудлагын дагуу аль болох гэрт нь очиж үзлэг, оношилгоо хийх зохион байгуулалтад шилжих;

2.1.6. Гэрийн тусгаарлалтад байгаа иргэнтэй утас, цахим сүлжээ ашиглан хяналт тавьж, хавьтлыг ажиглан шинж тэмдэг илэрсэн тохиолдолд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд хандахыг зөвлөх;

2.1.7. Үйлчлүүлэгч болон эмчлүүлэгч нарт улаанбурхан өвчний халдвараас сэргийлэх, вакцинжуулалтад хамрагдах талаар мэдээлэл түгээх;

2.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний халдварын сэргийлэлт, хяналтын талаар:

2.2.1. Эрүүл мэндийн сайдын 2018 оны “Халдварт өвчний тохиолдлыг тандах журам батлах тухай” А/527, 2019 оны “Дүрэм жагсаалт батлах тухай” А/536, “Заавар батлах тухай” А/537 дугаар тушаалыг мөрдөх;

2.2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, (вирус тээвэрлэх тэжээлт орчин, хамар хоолойн арчдас авах бамбар, гэх мэт), цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлж бэлэн байдлыг хангаж ажиллах;

2.2.3. Эмнэлэгт бөөгнөрөл үүсгэхээс сэргийлж амбулаторийн үзлэгийн цагийг утас болон цахимаар олгох, эмнэлгээр үйлчлүүлж байгаа иргэдэд амны хаалт хэрэглүүлэх;

2.2.4. Хүлээн авах, яаралтай тусламж, амбулаторийн хэсэгт шинж тэмдэгтэй үйлчлүүлэгчийн үзлэгийн өрөөг тусад нь зохион байгуулах, хөтөч сувилагч, дуугүй хөтчийг ажиллуулах;

2.2.5. Халдвартын тасаг болон тусгаарлах өрөөний бэлэн байдлыг хангаж, бусад тасгуудад түр тусгаарлах, ажиглалтын 1-2 өрөөг агааржуулалт сайтай, нарны гэрэл шууд тусах боломжтой байхаар зохион байгуулах;

2.2.6. Эмнэлгийн орчны цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт, агаар сэлгэлтийг сайжруулах;

2.2.7. Эрүүл мэндийн ажилтан улаанбурхан өвчнөөр өвдөөгүй, вакцинжуулалтад хамрагдаагүй тохиолдолд халдварын голомтод ажиллахдаа 95 түүнээс дээш хувийн шүүлтүүртэй амны хаалт хэрэглэх, хэрвээ өвдсөн, дархлаатай бол нэг удаагийн амны хаалт хэрэглэхээр нөөцийг бүрдүүлэх;

2.2.8. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой улаанбурхан өвчний халдварын тохиолдлын мэдээллийг ХӨСҮТ-ийн ipc@nccd.gov.mn цахим хаягаар тогтмол мэдээлэх.

2.3. Улаанбурхан өвчний тандалтын талаар:

2.3.1. Эрүүл мэндийн байгууллагаар тусламж авч байгаа бүх үйлчлүүлэгчдэд халууралт, ханиах, хамар, залгиур, нүдний салстын үрэвсэл, тууралтын шинж тэмдгийг тандах, бүтэн биеийн үзлэг хийж үзлэгийн хуудас, өвчний түүхэнд тэмдэглэх;

2.3.2. Үйлчлүүлэгч улаанбурхан өвчний халдварын нууц үе эсвэл шинж тэмдэг балархай үед эмнэлэгт орж бусад өвчтөн, үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтанд халдвар тархаах эрсдэл их тул халдвараас сэргийлж, тархвар судлалын асуумж, шинж тэмдгийн тандалтыг сайжруулах, халдварын тохиолдлыг эрт илрүүлэхэд онцгой анхаарч ажиллах;

2.3.3. Батлагдсан тохиолдлын хавьтлыг 72 цагийн дотор улаанбурхан, улаануудын эсрэг вакцинаар дархлаажуулах;

2.3.4. Хүлээн авах тасаг, хэсгээс оношилгоо, хэвтэн эмчлүүлэх тусламж үзүүлэх хүртэл бүх тасаг, нэгжид шинж тэмдгийн тандалт хийн, тархвар судлалын асуумж авч “Эрт илрүүлэх, эрт тусгаарлах” зарчмыг баримтлан бусад өвчтөнтэй хавьтал болохоос сэргийлэх арга хэмжээг эмнэлэг бүр хэрэгжүүлж ажиллах;

2.3.5. Эмнэлэгт улаанбурхан өвчний халдвар бүртгэгдсэн үед хавьтал болсон бусад үйлчлүүлэгчийг үндсэн тусламж, үйлчилгээ үзүүлж дуусмагц нууц үеийн хугацаанд харьяа эрүүл мэндийн байгууллага руу мэдээллийг илгээж хяналтад авах.

ГУРАВ. СУМ, ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ, ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА НАРТ

3.1. Дархлаажуулалтын цахим мэдээллийн санг бүрдүүлэх

3.1.1. 2006-2018 онд төрсөн бүх хүүхдийг заавал хийх үндэсний товллын дагуу улаанбурхан, гахай хавдар, улаануудын эсрэг вакцин болон 2012, 2015, 2016, 2017, 2019, 2023 онуудад зохион байгуулсан улаанбурхан, улаануудын эсрэг нэмэлт вакцинжуулалтад хамрагдсан эсэх мэдээллийг шалгаж, вакцинд хамрагдсан бол мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://health.gov.mn/>)-д бүрэн оруулах;

3.1.2. Хэрэв 16 хүртэлх насны хүүхэд улаанбурханы эсрэг товллын эсвэл нэмэлт вакцинжуулалтад хамрагдаагүй бол Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 тоот тушаалын дагуу улаанбурхан, гахай хавдар, улаанууд (УГУ)-ын эсрэг вакцинаар нөхөн дархлаажуулж, дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://health.gov.mn/>)-д бүртгэх;

3.1.3. Хэрэв 16-18 насны хүүхэд улаанбурханы эсрэг вакцинд хамрагдаагүй бол улаанбурхан, улаанууд (УУ)-ын эсрэг вакцинаар дархлаажуулж, цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn/>)-д бүртгэх;

3.1.4. 2019 оноос хойш төрсөн бүх хүүхдийг заавал хийх үндэсний товллын дагуу УГУ болон бусад товллын вакцинд бүрэн хамрагдсан эсэхийг шалгаж, вакцинд хамрагдсан мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэлд бүрэн оруулсан эсэхээ шалгах;

3.1.5. Хэрэв УГУ вакцинд хамрагдаагүй бол Эрүүл мэндийн сайдын 2015 оны 261 тоот тушаалын дагуу товллын УГУ вакцинаар нөхөн дархлаажуулж, цахим бүртгэлд тухайн насны хүүхдийн товллын дархлаажуулалтын мэдээллийг (<https://health.gov.mn/>)-д бүртгэх;

3.1.6. Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг вакцинд хамруулсан мэдээллийг дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn/>)-д бүртгэх.

3.2. Дархлаажуулалтын мэдээллийн сан бүрдүүлэхэд анхаарах зарим асуудал

3.2.1. Вакцинатор дархлаажуулалтын цахим бүртгэлд зөвхөн өөрийн эрхээр нэвтрэх ба мэдээллийн санд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцах;

3.2.2. Дархлаажуулалтын мэдээллийн санд мэдээлэл нөхөн оруулахдаа тухайн хүүхдэд улаанбурханы эсрэг вакцин хийсэн тэмдэглэгээ бүхий дархлаажуулалтын анхан шатны бүртгэлийн маягтууд (Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 тоот) дээрх мэдээлэлд үндэслэн бүртгэх;

3.2.3. Хэрэв хүүхдэд улаанбурханы эсрэг вакцинд хамрагдсаныг нотлох ямар нэгэн баримт бичиг байхгүй бол улаанбурханы эсрэг вакцинаар нөхөн дархлаажуулалт хийсний дараа дархлаажуулалтын цахим бүртгэлд мэдээллийг оруулах;


3.2.4. Хавьтлын хариу арга хэмжээ болон хавьтлын дархлаажуулалтын мэдээг өдөр бүр нэгтгэн аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газраас 17 цагаас өмнө Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албанд мэдээлэх;

3.2.5. Дархлаажуулалтын кабинетгүй эрүүл мэндийн байгууллагууд нь байгууллагын мэдээлэл технологийн ажилтнаас программд нэвтрэх түр эрхийг авч, эмнэлгийн халдвар судлагч эмчийн хяналтан дор дархлаажуулалтын цахим бүртгэл (<https://vis.health.gov.mn/>)-д бүртгэж оруулах;

3.2.6. Мэдээллийн сангийн үнэн зөв байдалд аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, дүүргийн Эрүүл мэндийн төвийн дархлаажуулалт хариуцсан мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллах;

Албан даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээллийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар нэгтгэн 2024 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус яамны Тохиолдлын удирдлагын тогтолцоо шуурхай удирдлагын багийн нарийн бичиг (мэргэжилтэн Б.Мөнхзул утас: 261629, цахим шуудангийн хаяг: munkhzul@moh.gov.mn, мэргэжилтэн Х.Бунд-Очир утас: 263652, цахим шуудангийн хаяг: bundochir@moh.gov.mn) ирүүлнэ үү.

САЙД



Т.МӨНХСАЙХАН